

МОНГОЛ ХЭЛНИЙ ЭСРЭГ УТГАТ ТОГТВОРТОЙ ХЭЛЛЭГИЙН ХЭВ ШИНЖИЙН ТУХАЙ АСУУДАЛД

Жанцангийн БАТ-ИРЭЭДҮЙ*

Хэлбичгийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

ЖЭ ЛИ (ЖАРГАЛ)**

МУИС-ийн докторант

Хураангуй. Монгол хэлний хэлцийн судалгаа улам нарийсаж байгаа бөгөөд түүний ойролцоо, эсрэг утгын цогц судалгаа бол эзнээ хүлээж байгаа сэдэв юм. Энэ илтгэлд монгол хэлний тогтвортой хэллэгийн эсрэгцэх чанар болон үүнд эсрэг үг, хэллэгийн үүрэг, эсрэг утгат зэргэд, эсрэг утга, далд утга, давхар санаа зэргийг монгол хэлэнд хэрхэн илэрхийлэхийг хэлний жишээ баримтаар дэлгэрэнгүй тайлбарлах болно. Мөн эдгээрийн соёл, нийгмийн ойлголтын онцлогийг гаргахыг хичээнэ.

Түлхүүр үг. Эсрэг утга, эсрэг утгат үг, эсрэг утгат хэллэг, эсрэг утгат хэлц, эсрэг утгат өгүүлбэр, эсрэг утгат зэргэд, хэлний нэгжийн эсрэгцэл,

Монгол хэлний тогтвортой хэллэг түүний дотор эсрэг утгатай тогтвортой хэллэгийн утгыг тайлбарлахын тулд үндэстний сэтгэлгээний талаар тодорхой сайн мэддэг, бүр судлаач нь уг хэлээр сэтгэдэг нэгэн байх ёстой гэж үзэж байна. Профессор Ж.Баянсан, “Үндэстний сэтгэлгээ бол юм үзэгдлийг эерэг, сөргөөр эсрэгцүүлэн үнэлэхтэй холбоотой. Ингэж үнэлэхдээ тусгай жишиг хэмжүүрийг үүсгэж шалгуур болгодог байна. Энэ жишиг хэмжүүр нь тухайн үндэстний эдийн болон оюуны уламжлалт соёлын зүйлийг илэрхийлсэн байдаг. Ингэхдээ уг үндэстэн шинээр таньж мэдсэн, ухаарч ойлгосон, шинээр бүтээж бий болгосон зүйл болгоныг адилтгах зүйрлэх аргаар илэрхийлэх үүрэгтэй байна. Ийм учраас сэтгэлгээ бол үндэстний шинжтэй, харин сэтгэхүй нь нийт хүн төрөлхтний шинжтэй зүйл гэж ялган ойлгож болно гэж үзэж байна.”¹ гэжээ.

Үүний адилтгах зүйрлэх гэдэгт нь аливаа зүйлийг адилтгах бас эсрэгцүүлэх

* © Ж.Бат-Ирээдүй 2024

E-mail: batireedui@mas.ac.mn

** © Жэ Ли (Жаргал) 2024

E-mail: 13910051931@163.com

¹ Ж.Баянсан, “Өвөрмөц хэллэгийг хэлний соёл судлалын үүднээс судлах нь” [Монгол хэл судлал: Хэлний соёл судлал, боть 14, Уб., 2022, 297 дахь талд]

буюу сөргөлдүүлэх гэдэг ойлголт багтана гэж бодож байна. Адилтгах зүйрлэх гэдэг дандаа эерэг зүйл байж болохгүй юм, тийм учраас эсрэг буюу сөрөг зүйл байж болно.

Мөн утга судлал, танин мэдэхүйд сүүлийн үед өргөн хүрээтэй хэрэглэж байгаа авалцуулан холбох, жишин адилсуулах гэдэг ойлголт нь мөн адил ойролцоо буюу синоним ба адил бус буюу эсрэг (антоним) ойлголтыг хамардаг ойлголт юм.

Монгол хэлний эсрэг утгыг ярихын өмнө эсрэг, эсрэг юм, эсрэг зүйл гэдэг ойлголтыг товч дурдах хэрэгтэй бөгөөд аливаа эсрэгцлийн үндэс нь хоёр зүйлийг эсрэг тэсрэг болгон авч үзэх санаанд тулгуурлах ба нэг юмыг нөгөөтэй эсрэгцүүлэн үзэх санаа нь хүний анхдагч сэтгэлгээний хамгийн түгээмэл ойлголт билээ.

Үндэстнүүдийн хооронд яг адилхан эсрэгцүүлдэг нийтлэг зүйл байдаг бол мөн тэс ондоо нэг үндэстний эсрэг гээд байгаа зүйлийг нөгөө үндэстэн энэ нээрээ эсрэг юм байна гэж хэлэхийн аргагүй зүйлийг эсрэг гэж сэтгэдэгт хэл, сэтгэлгээ, соёлын хамгийн гол онцлог оршино. Ийм учраас юуг юутай эсрэгцүүлэн үзэх нь тухайн хүн, тухайн үндэстний сэтгэлгээний онцлог болох юм. Мэдээж нийтлэг ойлгомжтой нь халуун $\neq$ хүйтэн, урт $\neq$ богино, том $\neq$ жижиг, өндөр $\neq$ нам гэх мэт хүн төрөлхтний нийтлэг сэтгэлгээ, танин мэдэхүйн эсрэгцэл байдаг бол нөгөө талд нь тухайн үндэстний ахуй орчин, аж төрөл, ёс заншил, шашин шүтлэг, оюуны ба эдийн соёлын онцлог, хүний ертөнцийг үзэх үзлээс үүдэлтэй нэгэн сонин хэв шинж байдаг нь тухайн хэлний тогтвортой хэллэгийн жишээнээс маш тодорхой харагддаг ажээ.

Аливаа хэлний нэгж хоорондын утгын харьцааг ойролцоо, эсрэг, төсөөт, зүйлчилсэн гэж дөрвөн үндсэн ангилал хийдэг. Үүнээс хэлний ойролцоо утга, эсрэг утга нь хамгийн түгээмэл харьцаа бөгөөд хэлний утга судлалд нарийн учир холбоотой болно. Тийм учраас бид монгол хэлний ойролцоо утгын тогтолцооноос гадна эсрэг утгын тогтолцоог сонирхон үзэж энэ удаа хэлний тогтвортой нэгж дээр эсрэгцэх харьцаа хэрхэн илэрч байгаа тухай товч танилцуулж байна.

Яг энэ тухай профессор Ж.Баянсан дурдахдаа “Үндэстний сэтгэлгээний онцлог нь хамгийн тод илэрсэн байдаг хэлний хэрэглэгдэхүүн нь тогтвортой хэллэг буюу зүйр цэцэн үг, сургаал үг, мэргэн үг, мөн өвөрмөц хэллэгийн зүйл байна. Үүнээс гадна хэрэв үндэстний соёлын учир холбогдол, сэтгэлгээний онцлогийг илэрхийлж байвал жирийн холбоо үгийг ч энэ үүднээс тайлбарлах боломжийг тэмдэглэх нь зүйтэй байна. Ийм хэллэгүүд нь юм үзэгдэл, үйл явдал, шинж чанар, нөхцөл байдал зэргийг сайн - муу, хэрэгтэй - хэрэггүй, зохистой - зохисгүй, таатай - таагүй гэх зэрэг эсрэгцсэн үнэлэмжээр үнэлэх тогтсон хэмжүүрийн илэрхийлэл болж байдгаараа үндэстний сэтгэлгээний хэв шинжийг судлах чухал хэрэглэгдэхүүн болдог байна.”² гэж бичсэн юм.

² Ж.Баянсан, “Эмэгтэй, эрэгтэй хүний тухай монгол сэтгэлгээний онцлог” [Монгол хэл судлал: Хэлний соёл судлал, боть 14, Уб., 2022, 335 дахь талд]

Ж.Бат-Ирээдүй, “Монгол хэлний ойролцоо, эсрэг утгат хэлцийн сан” Уб., 2007, 195 дахь талд

Монгол хэлний үг хэллэг эсрэг утгатай байж болдог шиг монгол хэлний хэлц үг хэллэг, хэлц нэгжүүд харилцан эсрэг утгатай байж болдог. Ийм учраас хэлц утга хоорондын эсрэг харьцааг тусгайлан судалж үзэх шаардлагатай байна. Энэ харьцааг Өвөр Монголын судлаачид “зөрчилт харьцаа” хэмээн нэрлэжээ. Бас үндсэн утга илэрхийлэх байж болох л нэр томьёо.

Эрдэмтэн М.Базаррагчаа, монгол хэлний эсрэг утгат их бага нэгжийг эсрэг бүтээвэр, эсрэг үглэвэр (үг), эсрэг өгүүлбэр, эсрэг цогцолбор гэж дөрөв ангилаад “... монгол хэлний эсрэг нэрийг нарийвчлан судлах шаардлагатай байна.” (2023:43) гэж үзсэн нь эсрэгцэх харьцаатай нэгжүүдийг тодорхойлсон төдийгүй тэдгээрийг хэлний баримт жишээгээр улам баяжуулан судлах шаардлагатай байгаа гэсэн үг гэж ойлгож байна.

Ийнхүү эсрэг утга буюу эсрэг харьцаа гэдэг ойлголт нь үг үгийн хооронд, үг хэлцийн хооронд, хэлц холбоо үгийн хооронд байж болох ба харин бид энэ илтгэлд зөвхөн эсрэг утгатай тогтвортой хэллэг, хэлц нэгжийн хувьд авч үзэх юм. Эсрэг харьцаатай хэлц үг хэллэг, тогтвортой нэгж, хэлц өгүүлбэрийн хувьд тусгайлан судлах нь чухал шаардлагатай бас сонирхолтой сэдэв юм.

Эдгээрээс монгол хэлний хувьд хамгийн сайн судлагдсан нь эсрэг утгат үг хэллэг юм. Монгол хэлний шууд буюу ил утгатай үг хэллэг эсрэг утгатай байж болдог шиг монгол хэлний шууд бус буюу далд утгатай үг хэллэг, хэлц нэгж, тогтвортой хэллэгүүд эсрэг утгатай байж болно. Энэхүү эсрэг утгатай хэлц үгийн талаар бид 2007 онд “Монгол хэлний ойролцоо, эсрэг утгат хэлц үгийн сан” хэмээх бэсрэг толь бичгийг хэвлүүлсэн билээ. Энэ өгүүлэлд тэрхүү толь бичгээс өргөн ашиглав.

Монгол хэлэнд эсрэг утгатай нь илэрхий ойлгомжтой хэлц үг хэллэг, тогтвортой нэгж арвин бий. Жишээлбэл, “алтан аяганаас ус уух $\neq$ амаар шороо үмхэх, ам алдах $\neq$ ам(аа) хичээх, аминд орох $\neq$ амийг нь авах, их гарын $\neq$ бага гарын, нохой гаслам $\neq$ сахал цантам, нуур нугас болох $\neq$ хонь чоно болох, нүдэнд дулаан $\neq$ нүдэнд хүйтэн, тангараг нь тонгорог болох $\neq$ гар гараасаа барилцах, туулай зүрхтэй $\neq$ чулуун зүрхтэй, нүүр хагарах $\neq$ нүүр буруулах, ганзага мялаах $\neq$ гуяа ганзагалах, тэнгэрт гаргах $\neq$ газар доогуур оруулах, царайчлах $\neq$ гуядах, цэцэг цэврүү шиг $\neq$ хөөтэй төлөг шиг, чих зөөлөн $\neq$ чих хатуу” гэх мэт үгийн сангийн утгаараа эсрэгцдэг үг оролцож бүтсэнээрээ эсрэг гэдэг нь илэрхий байдаг ийм эсрэг утгат хэлц үг олныг олж болно.

Ер нь ажиглахад монгол хэлний эсрэг утгатай тогтвортой нэгжийг эсрэгцүүлж байгаа нь түүний бүтцэд байгаа эсрэг утгатай үг нэлээд байх боловч бүх нэгжийн бүтцэд эсрэг утгатай үг байдаг гэж ойлгож болохгүй юм. Тухайн үгийн бүтцэд орсон үгээс үл хамааран ерөнхий илэрхийлж байгаа утгаараа эсрэг утгатай болох нөхцөл мөн арвин байна.

Тухайлбал бидний дээр авсан жишээнд их $\neq$ бага, тэнгэр $\neq$ газар, хатуу $\neq$ зөөлөн, гэх мэт эсрэг утгатай үгээс гадна цэцэг цэврүү $\neq$ хөөтэй төлөг, алтан аяга $\neq$ шороо, нуур нугас $\neq$ хонь чоно, туулай $\neq$ чулуу гэх мэт монгол хүний сэтгэхүйд

эсрэгцэж буудаг ойлголтыг ашиглан бүтээсэн тогтвортой хэллэг арвин байгаа тухай энэ өгүүлэлд хойно нэмж дурдана.

Ер нь монгол хэлний эсрэг утгатай хэлц үг хэллэгийн талаар судлаачид бичсэн зүйл цөөнгүй бий. Тухайлбал, проф.Д.Бадамдорж, “Утгын шинжлэлээр үзвэл, монгол хэлний өвөрмөц хэлц өөр хоорондоо ойролцоо утгат бас эсрэг утгат харьцаатай байна. Жишээ нь: эсрэг утгат өвөрмөц хэлц. Өр нимгэн-чулуун зүрхтэй, зүү орох зайгүй-хонь чоно хоёр шиг, ганзага мялаах-гуяа ганзагалах, толгой цохих-сүүл барих, чих зөөлөн - чих хатуу, тэмээ ямаа шиг - усны дусал шиг, нүд ирмэхийн зуур- бээрсэн аалз шиг гэх мэт.”³ гэжээ.

Доктор Л.Ганчимэг, Хэлц нэгжүүдийн бүтэц, утга зүйн тогтолцоог судалсан бүтээлдээ хоёр газар эсрэг хэлцийн тухай дурджээ. “Нүд хужирлах - сонирхон үзэх, нүд хорсох - үзэн ядах, дотор харанхуйлах - харамсах, ухаан балартах, дотор цэлмэх - санаа амрах, сэтгэл онгойх, ам чангатай - үг цөөтэй, ам султай - чалчаа гэх мэт эсрэг тэсрэг санааг илэрхийлдэг тогтворт нийлэмж үгийг эсрэг утгат хэлц үг гэнэ.” гэсэн бол нөгөө талаар “Хэлц нэгжийн тогтолцоот байдлыг илэрхийлэх өөр нэг онцлог бол тэдгээрийг эсрэгцсэн харьцаанд авч үзэх буюу ойролцоо утгатай хэллэг гэхийн адилаар түүнтэй эсрэгцүүлж эсрэг утгатай хэллэг хэмээн авч үзэх явдал юм. Эсрэг утгатай хэлц нэгж нь утгазүйн үндсэн шинжээрээ нэгдэж харин утгаараа эсрэгцсэн харьцаатай байна.”⁴ гэсэн боловч харин жишээ дурдсангүй.

Мөн эдгээрээс гадна монгол хэлэнд эсрэг утгат зэргэд гэж хэлж болох жишээ баримт арвин бий. Эсрэг зэргэдийг харьцуулан үзвэл түүнийг бүтээж байгаа гол “түүхий эд” нь түүний доторх эсрэг утгатай үг юм. Тийм учраас монгол хэлний эсрэг утгат үг бол эсрэг утгат өгүүлбэр, эсрэг утгат зэргэд бүтээх гол хэрэглүүр болно гэж үзэж болно. Ерөнхий утгаараа эсрэг утгат өгүүлбэр ч болох юм. Жишээлбэл, “Сайнд эцсэн илжиг шиг хашин, саарт ниссэн эрвээхэй шиг хөнгөн” гэсэн эсрэг утгат зэргэдийг авч үзвэл энэхүү өгүүлбэрийн гишүүн бүр нь эсрэг утгаар “зөрчилдөх” бөгөөд сайн $\neq$ саар, эцсэн илжиг (шиг) $\neq$ ниссэн эрвээхэй (шиг), хашин $\neq$ хөнгөн, гэсэн эсрэг утгат үг, хэллэг оролцож байж эсрэг утга илтгэж буй нь тодорхой байна.

Эсрэг утгат зэргэд буюу эсрэг өгүүлбэр нь бүтцээрээ адил боловч хэл зүйн утгаараа эсрэг байдаг. Өөрөөр хэлбэл эсрэг утгатай өгүүлбэрт орсон үгийн олонх нь утгаараа эсрэг байж, эсрэг санаа илтгэх, эсрэг санаа илтгэж байгаа учраас харилцан солих боломжгүй, өгүүлбэрт орж буй үгс нь үгсийн аймгийн хувьд нэг төрлийнх байх, өгүүлбэрийн бүтцийн хувьд янз бүр байж болох боловч санаа эсрэг буюу сөрөг байх, хоёр өгүүлбэр шууд эсрэг утга илтгэх, эсвэл хоёр эсрэг өгүүлбэрийн дундаас өөр нэгэн гол санааг илэрхийлэх гэх мэт хэв шинжтэй байна гэж үзэж болно.

Жишээлбэл, *балчир $\neq$ том, баян $\neq$ хоосон, гадна $\neq$ дотор, даамай $\neq$ гоомой (даамай нь даацтай, гоомой нь хуурамч), дээр $\neq$ доор, муу $\neq$ сайн, мэргэн $\neq$*

³ Д.Бадамдорж, Монгол хэлний үгийн сангийн утга зүй, УБ., 2015, 124 дэх талд.

⁴ Л.Ганчимэг, “Монгол хэлний хэлц нэгжийн бүтэц-утга зүйн тогтолцоо”, УБ., 2010, 18, 120 х.

мунхаг, нааш ≠ цааш, номхон ≠ догшин, нөхөр ≠ дайсан, өөд ≠ уруу, сайхан ≠ муухай, тэнэг ≠ мэргэн, урагш ≠ хойш, ууртай ≠ ухаантай, урд ≠ ард, урт ≠ ойр, үнэн ≠ худал гэх мэт эсрэг утгат тэмдэг үг, авал ≠ өгөл (**авалтай** хүн бардам, **өгөлтэй** хүн гөлөм), баяд ≠ ядуус, ерөөл ≠ хараал, нүгэл ≠ буян, тэнгэр ≠ газар, унд ≠ хоол (шүүдрээр унд хийх, шүлсээр хоол хийх) хүн ≠ мал гэх мэт эсрэг утгат нэр үг, авах ≠ орхих, авах ≠ өгөх, гэдийх ≠ бөхийх (өгөх хүн **гэдийх**, авах хүн **бөхийх**), инээх ≠ уурлах, ихдэх ≠ багадах, муулах ≠ магтах, өгөх ≠ гуйх, өөдлөх ≠ уруудах, суух ≠ босох, цадах ≠ өлсөх гэх мэт эсрэг утгат үйл үг, өрвөсхийх ≠ арвасхийх, өлбөлзөх ≠ шилбэлзэх, соохолзох ≠ гоохолзох, гэдэс хийх ≠ ухас хийх, гэх мэт эсрэг утгат дүрс дуурайх үг, халиу галуу ≈ хар хэрээ, тогтогос ≠ тогооны бариул, хурал ном ≠ хувь хишиг, зэрэг эсрэг утгат хоршоо үг, толгой цусдах ≠ ам тосдох гэх мэт хэлц үг оролцсон, эсрэг утга илэрхийлэх өгүүлбэрийн эсрэг утга нь илэрхий тод буюу шууд байна. Энд зарим нэг онцлог үгээрх жишээг нь хадаж өгөв.

Дээрх мэт үгийн сангийн шууд утгатай эсрэгцлийг танин тайлбарлах нь хэл, сэтгэлгээний нийтлэг байдлаас болоод амархан юм шиг харагдана. Харин тухайн ард түмний хэл, соёлтой холбоо бүхий шууд бус далд, зарим эрдэмтдийн томъёолсноор “хуурмаг эсрэг” үгийн утгыг таньж мэдэхэд их төвөгтэй. Энэ тухай профессор Ж.Баянсан бичихдээ “Утгын тухай асуудал өөрөө нэн ээдрээтэй үзэгдэл юм. Утга бол хийсвэрлэн сэтгэх үйл ажиллагааны явц, үр дүнгийн илэрхийлэл болдгийн дээр сэтгэцийн олон янзын үйлдэл утгад бас хамаатай. Утгыг тайлахад зөвхөн хэл шинжлэлийн мэдлэг хангалттай бус, хүний өөрийнх нь ерөнхий мэдлэг, үндэстний соёлын тухай мэдлэг, оюун билгийн чадвар, гүн ухаанч чанар, сэтгэл зүйн мэдлэг ухаан зэрэг хүнийг судалдаг хүмүүнлэгийн ухааны олон зүйлийн мэдлэг боловсрол зайлшгүй шаардлагатай болох ёстой нь сүүлийн үеэс улам бүр ойлгомжтой болсоор байна.”⁵ гэжээ. Тийм учраас ийм олон төрлийн мэдлэгийн үндсэн дээр тайлах, тайлбарлах ёстой зүйл бол хэлэхүйн эсрэгцэл буюу хуурмаг эсрэг утга юм. Өөрөөр хэлбэл аливаа үндэстний хэлэндээ туссан сэтгэлгээг тайлах, утгыг тайлбарлахад тухайн үндэстний тухай унаган мэдлэг зайлшгүй хэрэгтэй бөгөөд нөгөөтэйгүүр утгын судалгааг зөвхөн эх хэлтэн хүн л хийх боломжтой гэсэн үг гэж ойлгож бас болно.

Монгол хэл хэлэхүйн хувьд эсрэг утга илэрхийлэх эсрэг утгат өгүүлбэрээр арвин бөгөөд ийм өгүүлбэрт оролцож буй эсрэг утгат үг хэллэгийг хэлэхүйн буюу хуурмаг эсрэг утгат үг гэж үзэж болохоор байна. Жишээлбэл, ааг ≠ ажил (**ааг** нь ихдэж, **ажил** нь багадах), адууны алаг ≠ аяганы алаг, аяга ≠ агт (**аяганы** хариу өдөртөө, **агтны** хариу жилдээ), баатар ≠ бялзуухай (**баатар** биетэй, **бялзуухай** зүрхтэй), дэлхий ≠ мэлхий, (өөрийн үр **дэлхий**, хүний үр **мэлхий**), дээшээ харсан (аяга) ≠ дэлэнт (мал) (**дээшээ харсныг** биш **дэлэнтийг** харж суу.) намар ≠ хавар, нар ≠ нас, ноён ≠ нохой (**ноён** суудалтай, **нохой** гүйдэлтэй), өнгө ≠ өргөс (**өнгө** нь наанаа, **өргөс** нь цаанаа) намар ≠ хавар, нүд ≠ мөнгө (**нүд** улаан, **мөнгө** цагаан)

⁵ Ж.Баянсан, “Тогтвортой хэллэгийн когнитив шинж” [Монгол хэл судлал: Хэлний соёл судлал, боть 14, Уб., 2022, 256 дахь талд]

өөх тос $\neq$ ус нус, өөх $\neq$ хөө (өөрийн газар **өөх**, хүний газар **хөө**), өлөн бугын эвэр $\neq$ цагаан хурганы сүүл, өндгөө дарсан шувуу $\neq$ хүрэн эрээн бүргэд, нуруугаа үүрэх $\approx$ нусаа чирэх, алгаа тосох $\neq$ өрцөө татах, өдөр $\neq$ жил, ёмбогор $\neq$ төмбөгөр, могойн эрээн $\neq$ хүний эрээн, мөнгө $\neq$ өнгө, могойн хорлол $\neq$ сарны гэрэл, үг $\neq$ хүч, тос $\neq$ цус (сайн санааны үзүүрт **тос**, муу санааны үзүүрт **цус**), тус $\neq$ ус (**тус** хийсэн мартагдах, **ус** хийсэн санагдах), хазаар $\neq$ ташуур (Өглөө **хазаар**, орой **ташуур**.) үнэгний сүүлээр илэх $\neq$ үхрийн хэлээр долоох; шувуу $\neq$ мэлхий (сайн морь нисэх **шувуу** шиг, муу морь мөлхөх **мэлхий** шиг), хээрийн хоймор $\neq$ гэрийн хаяа (сайн эр **хээрийн хоймор** ясаа тавьдаг, муу эр **гэрийн хаяанд** ясаа тавьдаг), тэвнэ $\neq$ тэмээ (**Тэвнэн** чинээ нүх, **тэмээн** чинээ салхи), сүү $\neq$ сүх (үнэн үг сүүн хариутай, худал үг сүхэн хариутай), хөшөө $\approx$ ишиг (хөдлөх нь **хөшөө** шиг, хөхөх нь **ишиг** шиг) гэх мэт эсрэг утгат өгүүлбэрт хэлэхүйн эсрэг утгат үгээр эсрэг зэргэдийг бүтээх жишээ арвин байна.

Энэ тухай М.Базаррагчаа “Элгэн хад өөд төлгөн хуц мөргөнө” гэхэд “элгэн, төлгөн” гэсэн үг өөр хоорондоо утгаараа эрс өөр боловч авианы бүрэлдэхүүн төстэй болжээ. Гэвч энэ үг нь “бат, бөх, том” ба “нялх, бага” гэсэн утгаар эсрэгцсэн далд санаатай байх жишээтэй. Энэ мэтээр өгүүлбэрийн зэргэд хэрхэн бүтэх ёсыг утга хэлбэр болон гаргалгын талаас нарийвчлан үзэх нь тэгшлэх найруулга буюу “экспрессивный синтаксис” хэмээх зүйлд шууд хамаарах болно.”⁶ гэжээ. Яг үүнтэй адилхан “уул $\neq$ ууль”, “мөнхрөх $\neq$ өмхрөх” гэх мэт жишээ арвин байна.

Энэ бүхнээс монгол хэлний хэлэхүйн эсрэг утгат үг буюу яагаад адуу, аяга хоёрыг, яагаад ноён нохой хоёрыг, яагаад нүд мөнгө хоёрыг, яагаад өөх тос, ус нус гэх хоршоо үгийг, яагаад өлөн бугын эвэр, цагаан хурганы сүүлийг эсрэгцүүлэх болов гэдгийг нэг бүрчлэн үзэж утга соёлын холбоо хамаарлыг гаргавал нэн сайн болох бөгөөд монгол хэлний эсрэгцэх утгын харьцааны бүрэн судалгаа хийх явцад эдгээрийг гаргаж чадах юм.

Мөн -тай $\neq$ гүй, -хгүй $\neq$ дэг гэх мэт хэлний зүйн эсрэг утгат нөхцөлийн үүргээр эсрэг зэргэд бүтээх явдал монгол хэлэнд арвин байна. Жишээлбэл, ах дүүтэй $\neq$ ах дүүгүй, ёроолтой $\neq$ ёроолгүй, мэдэхгүй $\neq$ мэддэг (**мэдэхгүй** хүн мэлхий шиг, **мэддэг** хүн эрдэнэ шиг), таньдаг $\neq$ таньдаггүй (**таньдаг** хүндээ хайлсан тугалга шиг, **таньдаггүй** хүндээ хадаастай гутал шиг),

Бидний судлан үзэж буй монгол хэлний эсрэгцлийн категориыг бас нэгэн сонин талаас ажигласан эрдэмтэн бол Ж.Баянсан багш юм. Тэрбээр, “... монгол хэлний тогтвортой хэллэгийг эсрэгцсэн ойлголтуудын солбицолд оруулж, зүйлчлэн ангилах боломжтой байгаа юм.” гээд харамч - өглөгч, баян, баяжих - ядуу, хоосон ядуурах гэсэн эсрэгцсэн ойлголтыг судалж, олон жишээгээр тайлбарлаад “Энэ мэтээс үзвэл, аливаа тогтвортой хэллэгийн бүрэлдэхүүнд орсон үг болгон “хэлээр үүтгэн цогцлоох сэтгэхүйн” нэгэн хэлбэрийн бүтээгдэхүүн, үйл явц, мах бод байдаг учраас тэдгээрийн далд утгасыг нээж илрүүлэх нь нэн

⁶ М.Базаррагчаа, “Монгол хэлний ойролцоо нэгжийг судлах асуудалд” [Б.Мөнгөнцэцэг, “Монгол хэлний ойролцоо зэргэд, Уб., 2012, 11 дэх талд]

чухал асуудал болох нь ойлгомжтой байна.” гэжээ. Тийм учраас бид монгол хэлний тогтвортой хэллэгийн эсрэг утга илэрхийлэх хэв шинжийг хэлний арвин баялаг жишээ баримтаар олж харж, тогтвортой хэллэг бүрийн далд утга, эсрэг утгыг монгол үндэстний хэлний соёл, танин мэдэхүйтэй холбон тайлбарлахад бидний энэхүү ажлын гол зорилго орших юм.

Дүгнэлт

Аливаа хэлний тогтвортой хэллэгийг ойролцоо болон эсрэг утгаар нь ангилан толилж болох ба монгол хэлний тогтвортой хэллэгийн хувьд ийнхүү хэлц хэллэг тус бүрийн утгыг хөөж, үгийн утга, соёлын гарвалыг судлан үзвэл монгол үндэстний аливааг эсрэгцүүлэх сэтгэлгээний онцлогийг харуулах маш сонирхолтой үр дүн харагдах нь тодорхой байна. Цаашид улам гүнзгийрүүлэн аль болох арвин жишээ баримт дээр суурилсан судалгаа хийж чадвал монгол хэлний тогтвортой хэллэгийн эсрэгцэх харьцааны онцлог, түүний хэв шинжийг улам тодруулж чадна гэж үзэж болно.

Ном зүй

- Д.Банди нар**, (2022) *Монгол хэлний утга эсрэг үгийн товч толь*. Улаанбаатар: D. Bandi et al., (2022) *A brief dictionary of the antonyms in Mongolian*. Ulaanbaatar:
- Д.Бадамдорж**, (2006, 2015) Монгол хэлний үгийн сангийн утга зүй. Улаанбаатар: D. Badamdorj, (2006, 2015) *The semantics of the Mongolian lexicon*. Ulaanbaatar:
- Ж.Бат-Ирээдүй нар**, (2007) *Монгол хэлний ойролцоо, эсрэг утгат хэлцийн сан*. Улаанбаатар: J. Bat-Ireedui et al., (2007) *Lexicon of Mongolian antonym and synonymic phrases*. Ulaanbaatar:
- Б.Мөнгөнцэцэг**, (2012) *Монгол хэлний ойролцоо зэргэд*. Улаанбаатар:
- М.Базаррагчаа**, (2013) *Монгол хэлний эсрэг үгийн судалгааны тойм*. (толийн оршил) M. Bazarragchaa, (2013) *A review of Mongolian antonyms*. (Introduction to the dictionary)
- Б.Одончимэг**, (2013) *Монгол хэлний эсрэг үгийн толь*. Улаанбаатар: B. Odonchimeg, (2013) *A dictionary of Mongolian antonyms*. Ulaanbaatar:
- Ж.Бат-Ирээдүй**, (2014) Монгол хэлний хэлц үг, хэллэгийн утга хэрэглээ Улаанбаатар: J. Bat-Ireedui, (2014) *The meaning and use of Mongolian idioms and phrases*. Ulaanbaatar:
- Ж.Баянсан**, (2016) *Соёл, хэл үндэстний сэтгэлгээ*. Улаанбаатар: 2016 J. Bayansan, (2016) *Culture, language and national mentality*. Ulaanbaatar: 2016
- Ж.Бат-Ирээдүй**, (2019) *Монгол хэлний ойролцоо, эсрэг утгат үгийн толь бичиг*. Улаанбаатар: 2019 J. Bat-Ireedui, (2019) *A dictionary of Mongolian antonym*

and synonym. Ulaanbaatar: 2019

Ж.Баянсан, (2019) *Монгол хэлний зүйрлэсэн үг хэллэгийн утга соёлын тайлбар толь*. Улаанбаатар: 2019 J. Bayansan, (2019) *A dictionary of the meaning and culture of the Mongolian metaphors*. Ulaanbaatar: 2019

Ж.Бат-Ирээдүй, (2022) *Үгийн өвгөн утгын таяг тулмуй*. Улаанбаатар: J. Bat-Ireedui, (2022) *The old word walks with semantic crutch*. Ulaanbaatar:

Д.Заяабаатар (ер.ред), (2022) “Монгол хэл судлал 14” (Танихуйн хэл шинжлэл, хэлний соёл судлал), Улаанбаатар: 2022 D. Zayabaatar (ed.), (2022) “*Mongolian language studies 14*” (Cognitive linguistics, language culture studies), Ulaanbaatar: 2022

Charles W.Kreidler. [Introducing English Semantics, Routledge, New York, London: 2014]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.